



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар A/798

Арвайхээр

**Аймгийн “Тэмээчдийн баяр-2020”  
арга хэмжээ зохион байгуулах тухай**


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тэмээ бүхий сумдууд оролцсон аймгийн “Тэмээчдийн баяр-2020” арга хэмжээг Төгрөг суманд 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн “Тэмээчдийн баяр-2020” арга хэмжээний үеэр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир, спортын газрын дарга (Б.Энхтөр)-т даалгасугай.

3. Дээрх зардал 7360000 (долоон сая гурван зуун жаран мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101527

Аймгийн Засаг даргын 2019 оны 12  
дугаар сарын 12-ны өдрийн 177/19 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН “ТЭМЭЭЧДИЙН БАЯР”-2020 АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Б.Энхтөр аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн  
тамир, спортын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Ж.Намсрайжав – “Төгрөг-Тэмээчдийн холбоо”-ны  
Тэргүүн дарга

Гишүүд: Т.Ариунболд- аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал  
жуулчлалын газрын дарга

С.Цэдэнбалжир- аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж  
ахуйн газрын дарга

О.Ганбат- аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

Б.Цэнгэл- аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн  
газрын Мал аж ахуйн албаны дарга

А.Нямдаваа- аймгийн Засаг даргын дэргэдэх Мал эмнэлгийн газрын  
дарга

Н.Баярцэнгэл- аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл,  
урлагийн газрын мэргэжилтэн

Ч.Чинзориг- Богд сумын Засаг дарга

Р.Намгилрагчаа- Гучин-Ус сумын Засаг дарга

Д.Баатарчулуун- Баруунбаян-Улаан сумын Засаг дарга

А.Мөнхбат-Баянгол сумын Засаг дарга

Б.Батбаяр- Төгрөг сумын Засаг дарга

С.Дамдинпүрэв- Сант сумын Засаг дарга

Д.Өсөх-Эрдэнэ- Төгрөг сумын Соёлын төвийн эрхлэгч

Аймгийн Засаг даргын 2019 оны 19 дугаар сарын 23-ны өдрийн 119 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН “ТЭМЭЭЧДИЙН БАЯР-2020” АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Хэрэглэгдэх зүйлс	Зориулалт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Атан тэмээ /медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал/	Тэргүүн	1	Ш	1.700.000	1.700.000
		Дэд	1	Ш	400.000	400.000
		Гутгаар	1	Ш	350.000	350.000
		Дөтгөөр	1	Ш	300.000	300.000
		Айргын тав	1	Ш	250.000	250.000
		Тусгай байр	5	Ш	50.000	250.000
2.	Тормон тэмээ /медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал/	Тэргүүн	1	Ш	1.500.000	1.500.000
		Дэд	1	Ш	400.000	400.000
		Гутгаар	1	Ш	350.000	350.000
		Дөтгөөр	1	Ш	300.000	300.000
		Айргын тав	1	Ш	250.000	250.000
		Тусгай байр	5	Ш	50.000	250.000
3.	Шилмэл буур /тууз, өргөмжлөл, мөнгөн шагнал/	Тэргүүн	1	Ш	200.000	200.000
		Дэд	1	Ш	180.000	180.000
		Гутгаар	1	Ш	150.000	150.000
4.	Шилмэл ингэ /тууз, өргөмжлөл, мөнгөн шагнал/	Тэргүүн	1	Ш	200.000	200.000
		Дэд	1	Ш	180.000	180.000
		Гутгаар	1	Ш	150.000	150.000
Дүн						7360.000